



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 99

Номгон

**Гурванбулаг сумын дунд сургуулийг
Бямбын Даваасүрэнгийн нэрэмжит болгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг мөнхжүүлэх журам”-ын 6 дахь хэсгийн 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гурванбулаг сумын дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш, доктор, Бямбын Даваасүрэнгийн нэрэмжит болгосугай.
2. Монгол Улсын гавьяат багш, доктор Бямбын Даваасүрэнгийн нэрэмжит Гурванбулаг сумын дунд сургуулийн хаяг, албан хэвлэмэл хуудасны загварыг баталж, нэрэмжит болгосонтой холбоотой ажил үйлсийг хойч үеийнхэнд таниулж, гавьяат үйлсийг нь алдаршуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117041